



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/16

Алтрага

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, амьтны гоц халдварт өвчин зөөвөрлөгдөн дамжин тархах болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гоц халдварт “Хонины цэцэг”, “Бог малын мялзан”, “Гахайн африкийн мялзан” өвчний тохиолдол бүс нутгаас мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хязгаарласугай.

2.Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт тархварзүйн судалгааг хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг тархварзүйч (Д.Энхтайван)-д, малчид, иргэд, бизнес эрхлэгч нарт мэдээлэл түгээж ажиллахыг багийн Засаг дарга нар болон мал эмнэлгийн ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжийн эздэд даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Даваажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010039